

# “Дорнод худалдаа” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлан

Илтгэгч:

Гүйцэтгэх захирал П.Гунгааням

## Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

- “Дорнод Худалдаа” ХК нь анх 1922 онд Цэцэнхан аймгийн Баянтүмэнтэй Хан-Уулын хошуунд 150 хүнийг хоршоонд элсүүлэн 2119 лан мөнгө, 135 толгой мал, 222 эр хонин сүрэг хувь нийлүүлсэн хөрөнгөтэй “Монгол ардын харилцан туслалцах хоршооны 5-р хэсэг” нэртэйгээр байгуулагдсан.
- 1990 оноос Монгол улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжин орсноор төрийн өмч давамгайлсан “Есөн-Эрдэнэ” ХК болсон.
- 1998 онд төрийн өмчийн эзэмшлийн 50,3 хувийг битүүмжилсэн дуудлага худалдаагаар худалдаж хувийн өмчид шилжүүлснээр 73969 ширхэг хувьцаатай, 300 хувьцаа эзэмшигчтэй “Дорнод худалдаа” ХК болон өөрчлөгдсөн.

Манай компани нь Дорнод аймагт төдийгүй зүүн бүсийн ард иргэдэд хүрч үйлчилдэг Зүүн бүсийн худалдааны төв болон үйл ажиллагаа өргөжүүлсэн билээ.

Зүүн бүсийн худалдааны төв нь 2400мкв талбай бүхий хүнс, бараа, ногоо зах, 725кв/м-ийн багтаамж бүхий хөргөлттэй агуулах, 300тн-ийн сонгинын зоорь, 100тн –ын махны хөргөлттэй агуулах, 260тн-ын төмсний зоорь, 100-150 хүнийг нэгэн зэрэг хүлээн авах хүчин чадалтай “Восток” ресторан, 250 мкв талбай бүхий барааны дэлгүүр зэрэг төрөлжсөн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2006 онд 60 гаруй сая төгрөгөөр 324 мкв талбай бүхий орчин үеийн тоноглолтой махны худалдааны төвийг ашиглалтанд оруулж 50 орчим хүний ажлын байрыг шинээр бий болгосон. Мөн 2007 онд хөргөлтийн агуулахыг шинээр тоногосноор махыг жилийн 4 улиралд хэвийн температурт хадгалж, ард иргэдийг эрүүл хүнсээр хангах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2011 онд 120 гаруй сая төгрөгөөр 110,5мкв талбай бүхий 2 давхар орчин үеийн хийц загвартай худалдааны төвийг ашиглалтанд оруулж 40 гаруй хүний ажлын байрыг бий болгосон. Мөн 2014 онд 260 гаруй сая төгрөгөөр 130мкв талбай бүхий 3 давхар үйлчилгээний төвийг ашиглалтанд оруулж арилжааны банкууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Зүүн бүсийн худалдааны төвд өдөртөө 700 гаруй худалдаа эрхлэгч тогтмол худалдаа үйлчилгээ явуулж өдөрт давхардсан тоогоор 2000 гаруй иргэдэд үйлчилж, ингэснээр аймгийн нийт бараа эргэлтийн 60%-ийг худалдааны төвөөс хангаж байна.

## ***НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА***

Одоо тус компани нь 40 гаруй ажилтан, ажиллагсадтай, өөрийн үл хөдлөх эд хөрөнгийг иргэд, бусад аж ахуй нэгж байгууллагуудад оффис, үйлдвэрлэл үйлчилгээ, худалдааны чиглэлээр түрээслэх үйл ажиллагаа эрхлэн явуулж, түрээсийн орлогоор үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэн өр үүсгэхгүй ажиллаж байна.


Компани нь санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртөгийн албан татвар, газрын төлбөр болон, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж татвар нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

2015 оны жилийн эцэст 675.9 сая төгрөгийн орлого олж 51,2 сая төгрөгийн борлуулалтын өртөг болон 574,6 сая төгрөгийн зардал гаргаж 50.0 сая төгрөгийн ашигтай ажилласан. Үүнээс цалин хөлсний зардалд 138,5 сая төгрөг, НДШ-ийн зардалд 15,1 сая төгрөг, гэрээт ажилчдын цалин хөлс 4,0 сая төгрөг, засвар үйлчилгээний зардалд 50,5 сая төгрөг, ашиглалтын зардалд 85,4 сая төгрөг, удирдлагын 31,6 сая төгрөг, газрын төлбөрт 3,4 сая төгрөг, ҮХЭХАТатварт 5,4 сая төгрөг, ХХОАТ 13,7 сая төгрөг, ААНОАТ 5,0 сая төгрөг, НӨАТ 67,5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2015 оны жилийн эцсийн мал тооллогоор компанийн туслах аж ахуй болх мал сүргийн тоо 4 төрөлд өсөж нийт 1241 толгой болсон байна. Мал аж ахуй нь манай компанийн үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд саалийн болон махны чиглэлийн үхрийн фермерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах нэг томоохон салбар болохоор тусгагдаад байна.

# ***ХОЁР: БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР***

Компани нь Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, нягтлан, нярав, зохион байгуулагч, “Восток” рестораны ажилчид зэрэг нийт 42 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.





## ***ГУРАВ: НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТАЛААР***

Тус компанид ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт гарсан 100 гаруй ахмад настанг Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу ахмадын баяр болон сар шинийн баяраар хүлээн авч гарын бэлэгийг жил бүр тогтмол олгож байна.

Мөн ажилчдын нийгмийн болон ар гэрийн амьдралд туслах зорилгоор жилдээ 200 гаруй тонн нүүрс олгож, ар гэрийн гачигдал гарсан 10 гаруй хүнд буцалтгүй тусламж болох хүүхдийн сургалтын төлбөр, эмчилгээний төлбөр гэх мэт нийт энэ онд 5,5 сая төгрөг зарцуулсан. Мөн худалдаа эрхлэгчдид болон жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор давхардсан тоогоор 100 гаруй хүмүүсийн өргөдөл гомдолыг хүлээн авч 6,5 сая төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлт, шагнал урамшуулал олгосон.

Зарим ажилчдыг туршлага судлах зорилгоор БНХАУ-ын Манжуур хотруу 5 хүнийг 3 хоног , 1 хүнийг Өвөрмонголын Ордос хотруу 7 хоног компанийн зардлаар аялуулсан.



# ДӨРӨВ: САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хураангуй.

№	А. Үлдэгдэлийн тэнцэл	2014.12.31	2015.12.31
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	15,422,316	36.684.463
2	Бусад авлага	40,480,791	77.833.658
3	Бараа материал	83,606,398	80.369.333
4	Мал амьтад	9,827,000	9.827.000
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>351,892,395</b>	<b>204.714.454</b>
5	Үндсэн хөрөнгө	847,740,995	909.500.000
6	Хуримтлагдсан элэгдэл	-172,475,899	-189.529.024

7	<b>Бусад үндсэн хөрөнгө</b>	<b>108,442,041</b>	<b>134.270.000</b>
8	Хуримтлагдсан элэгдэл	-62,541,226	-71.212.151
9	Бусад эргэлтийн бус хөрөнгө	11,837,100	
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>733,003,011</b>	<b>783.037.825</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>882,339,516</b>	<b>987.752.279</b>
10	Дансны өглөг		
11	Татварын өр	4,951,588	5.788.122
12	Бусад богино хугацаат өр төлбөр	40,000,000	31.115.600
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>44,942,588</b>	<b>36.903.722</b>
13	Эздийн өмч	299,199,900	299.199.900
14	Эздийн өмчийн бусад хэсэг	89,192,814	156.183.524
15	Хуримтлагдсан ашиг	449,004,214	495.465.133
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>837,396,928</b>	<b>950.848.557</b>

	<b>ӨР ТӨЛБӨР ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>882,339,516</b>	<b>987.752.279</b>
16	<b>Б.Орлого үр дүнгийн тайлан</b>	<b>2014 оны 12 сарын 31</b>	<b>2015 оны 12 сарын 31</b>
17	Цэвэр орлого	887,699,174	675.920.266
18	ББӨ	88,085,935	51.217.816
19	Нийт ашиг	799,613,239	624.702.450
20	Үйл ажиллагааны зардал	773,903,060	574.623.644
21	Ердийн ажиллагааны ашиг	25,710,179	50.078.806
22	Орлогын албан татварт	2571017	5.007.880
23	Тайлант үеийн цэвэр ашиг	23,139,162	45.070.926

2015 оны жилийн эцсийн байдлаар 675.9 сая төгрөгийн борлуулалт хийж 574.6 сая төгрөгийн зардал гаргаж 50.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө оны эхэнд 15.4 сая төгрөг, 746.6 сая төгрөгийн орлого олж 725.3 сая төгрөгийн зарцуулалт хийж 36.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Зардлыг бүтцээр нь авч үзвэл 75,2 хувь нь үйл ажиллагааны зардалд, 24,8 хувь нь бусад зардалд эзэлж байна. 2015 оны жилийн эцсээр 23.1 сая төгрөгийн ашигтай ажилласан бол 2016 оны жилийн эцэст 45.0 сая төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оныхоос 21.9 сая төгрөгөөр өссөн байна.

## ***ТАВ: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА***

Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр, аюулгүй байдал эрүүл ахуйн талаар компанийн хэмжээнд сургалт мэдээллийг хийж хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг өдөр тутам мөрдөж ажиллаж байна. Хүнсний эрүүл ахуйн чиглэлээр холбогдох хуулийн хүрээнд МХГ, ХХААГазар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан худалдаа эрхлэгчдийн ажиллах орчин нөхцөл, хөдөлмөрийн харилцаанд үүсэх аливаа асуудлыг шийдвэрлэж байна.

### ***ЗУРГАА: БҮТЭЭН БАЙГУУЛААЛТ***

Зүүн бүсийн худалдааны төвийн төв хаалга, хүнс барааны захын гадна өнгө, захын дээвэр агуулах складуудын дээврийн ажилд нийт 50,5 сая төгрөгийн их засварын ажил хийж гүйцэтгэсэн байна. Мөн Хан-Уул дэлгүүр, восток рестораны дээврийн их засвар, захын хашаанд цэвэр усны төв шугамыг бүрэн сольж засварласан, 2 бөөний төв шинээр барьж ашиглалтанд оруулсан, үсчин, тавилгын цехт бүрэн засвар хийж гүйцэтгэсэн зэрэг 2015 онд хийж гүйцэтгэсэн бүтээн байгуулалтууд олон байна.


## ДОЛОО: ҮНДСЭН ба ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Компанийн нийт хөрөнгө тайлант оны эцэст 987.752.,3 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэлээс 37.032.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хөрөнгийн дүнгийн 20%-ийг эргэлтийн хөрөнгийн дүн, 80%-ийг эргэлтийн бус хөрөнгийн дүн эзэлж байна.

### А. Эргэлтийн хөрөнгө /мян.төг/


№	Балансын зүйл	2014.12.31	2015.12.31	Өөрчлөлт	Нийт эргэлтийн хөрөнгийн дүнд эзлэх хувь
0	1	2	3	4	5
1	Мөнгө	15.422.3	36.684.4	21.262.1	17.9
2	Дансны авлага		60.6	60.6	0.03
3	Бусад авлага	57.102.6	77.772.9	20.670.3	38
4	Бараа материал	83.606.4	80.369.3	-3.237.1	39.2
5	Мал амьтад	9.827.0	9.827.0	0	4.87
6	ДҮН	165.958.3	204.714.4	38.756.1	100

# Үйл ажиллагааны орлогыг төрөлөөр нь задалбал






# Авлага, өр төлбөрийн харьцуулалт



# Татварын дараах цэвэр ашиг /харьцуулалт/



## ***НАЙМ: 2016 ОНЫ ЗОРИЛТ***

- Түрээсийн үлдэгдэлгүй санхүүгийн жилийг угтах
- Ажилтан нэг бүрийн ажлын цагийн хуваарь, үүрэгт ажлын бүтээмжийг судлах, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах
- Худалдаа эрхлэгчдийн сэтгэл ханамж, эдийн засгийн боломжит нөхцлийн талаар судалгаа хийх
- 2016 оны бизнес төлөвлөгөөний дагуу шинэ худалдааны төвийн бэлтгэл ажлыг хангаж ажиллах
- Цахилгаан болон сантехникийн нарийвчилсан схем гаргах.
- 2016 оны төлөвлөгөөнд тусгагдсан засваруудыг шат дараалан гүйцэтгэх
- 2016 оны орлогыг өнгөрсөн оны санхүүгийн жилээс нэмэгдүүлэх

**Анхаарал хандуулсан та  
бүхэнд баярлалаа.**